

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/90/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт.....	16
5.2 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	17
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	17
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	17
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХК	Хувьцаат компани
ТӨХК	Төрийн өмчит Хувьцаат компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.20 № 4/39

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Засгийн газрын "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолын дагуу байгууллагын албан хаагчдын цалинг 2023 оны 7 дугаар сарын 01-ээс шинэчлэн тогтоож, орон нутагт ажилласны нэмэгдлийг 70 хувиар тооцож олгосон байна. Үүнтэй холбоотойгоор цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлууд өмнөх оноос 83,0 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

019020032

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,978,982.00	5,343,402.00
33	АВЛАГА	00.00	94,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	94,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,978,982.00	5,249,402.00
354	Хангамжийн материал	2,978,982.00	5,249,402.00
35410	Бичиг хэргийн материал	966,290.00	1,086,800.00
35420	Аж ахуйн материал	1,017,920.00	2,910,220.00
35430	Сэлбэг хэрэгсэл	260,000.00	260,000.00
35440	Түлш, шатах тослох материал	734,772.00	992,382.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,902,495.38	27,441,677.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,902,495.38	27,441,677.85
392	Биет хөрөнгө	17,902,495.38	27,441,677.85
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,000,000.00	33,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,624,999.85	-26,124,999.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	12,869,450.00	25,911,760.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,226,535.27	-9,057,818.43
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,305,405.00	9,820,405.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,420,824.50	-6,107,668.91
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-880,000.00	-880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	20,881,477.38	32,785,079.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	94,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	94,000.00
413	Өглөг	00.00	94,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	94,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	20,881,477.38	32,691,079.85
51	Засгийн газрын хувь оролцоо	20,881,477.38	32,691,079.85
512	Хуримтлагдсан үр дүн	20,881,477.38	32,691,079.85
51210	Өмнөх үеийн үр дүн	20,881,477.38	20,881,477.38
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	11,809,602.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	20,881,477.38	32,785,079.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны к	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	187,599,800.00	319,305,903.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	27,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	27,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	187,572,800.00	319,305,903.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	42,665,203.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	42,665,203.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	187,572,800.00	276,640,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	187,572,800.00	276,640,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	196,339,835.96	307,496,300.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	196,339,835.96	307,496,300.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	193,526,735.96	293,948,817.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	125,330,034.28	216,753,360.63
210101	Үндсэн цалин	125,330,034.28	198,601,762.94
210102	Нэмэгдэл	00.00	17,982,364.86
210104	Урамшуулал	00.00	169,232.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,666,254.29	41,245,069.86
210201	Тэтгэврийн даатгал	10,735,376.40	38,644,354.77
210202	Тэтгэмжийн даатгал	1,157,320.91	651,204.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,003,393.50	520,963.22
210204	Ажилгүйдлийн даатгал	250,849.36	126,141.96
210205	Эрүүл мэндийн даатгал	2,519,314.12	1,302,405.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,550,278.76	00.00
210302	Түлш, халаалт	5,550,278.76	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,393,668.00	6,012,649.05
210401	Бичиг хэрэг	1,602,850.00	1,031,190.00
210402	Тээвэр, шатахуун	3,963,768.00	3,131,590.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	945,670.00	1,205,619.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	881,380.00	644,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,188,900.00	215,600.00
210604	Урсгал засвар	3,188,900.00	215,600.00
2107	Томилот, зочны зардал	12,641,500.00	18,341,100.00
210702	Дотоод албан томилот	12,641,500.00	18,341,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	492,750.00	789,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	152,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	283,300.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	76,150.00	52,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,263,350.63	10,591,787.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	515,770.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,470,000.00	944,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,013,367.96	9,132,017.53
2113	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,813,100.00	13,547,483.46
21132	Бусад урсгал шилжүүлэг	2,813,100.00	3,908,885.28
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,813,100.00	3,908,885.28
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	9,638,598.18
213403	Төвлөрүүдэх шилжүүлэг	00.00	9,638,598.18
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8,740,035.96	11,809,602.47
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8,740,035.96	11,809,602.47

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны к	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	187,572,800.00	319,305,903.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	187,572,800.00	319,305,903.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	42,665,203.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	42,665,203.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	187,572,800.00	276,640,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	187,572,800.00	276,640,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	187,572,800.00	300,634,703.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	187,572,800.00	300,634,703.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	171,979,717.33	287,087,219.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	125,330,034.22	229,404,046.93
210101	Үндсэн цалин	84,386,352.87	109,853,360.78
210102	Нэмэгдэл	30,089,826.45	94,225,528.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,104,000.00	7,972,000.00
210104	Урамшуулал	4,749,854.90	17,353,157.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,666,254.35	28,594,383.56
210201	Тэтгэврийн даатгал	10,653,052.85	21,214,912.09
210202	Тэтгэмжийн даатгал	1,253,300.29	1,792,628.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,002,640.30	1,659,901.05
210204	Ажилгүйдлийн даатгал	250,660.09	353,273.62
210205	Эрүүл мэндийн даатгал	2,506,600.82	3,573,668.74
210302	Түлш, халаалт	5,550,278.76	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,735,720.00	6,802,869.05
210401	Бичиг хэрэг	1,520,530.00	1,048,700.00
210402	Тээвэр, шатахуун	4,165,000.00	3,389,200.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	945,670.00	1,577,619.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,104,520.00	787,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,673,180.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,673,180.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	12,641,500.00	18,000,000.00
210702	Дотоод албан томилолт	12,641,500.00	18,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	492,750.00	1,424,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	900,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	283,300.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн гатвар	76,150.00	55,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	30,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,890,000.00	1,861,070.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	575,970.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,890,000.00	1,285,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,593,082.67	13,547,483.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,813,100.00	3,908,885.28
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,813,100.00	3,908,885.28
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,779,982.67	9,638,598.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,779,982.67	9,638,598.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	18,671,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	18,671,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	18,671,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	18,671,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	18,671,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-18,671,200.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	38,226,445.03	00.00	38,226,445.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-8,604,931.69	00.00	-8,604,931.69
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	20,881,477.38	00.00	20,881,477.38
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	20,881,477.38	00.00	20,881,477.38
D01	2023 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	20,881,477.38	00.00	20,881,477.38
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	20,881,477.38	00.00	20,881,477.38
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,809,602.47	00.00	11,809,602.47
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	32,691,079.85	00.00	32,691,079.85

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	I НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	38,762,257.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	38,762,257.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	38,762,257.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	34,489,406.42
210102	Нэмэгдэл	0.00	26,416,727.28
210104	Урамшуулал	0.00	8,072,679.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	4,272,851.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	3,223,595.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	208,761.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	392,807.50
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	41,752.80
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	405,934.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00
	II ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	38,762,257.42
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	38,762,257.42
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	38,762,257.42
	IV НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	187,572,800.00	174,792,817.33	276,640,700.00	270,905,047.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	187,572,800.00	174,792,817.33	276,640,700.00	270,905,047.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	184,706,100.00	171,979,717.33	271,990,700.00	266,996,162.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,772,100.00	125,330,034.22	195,473,300.00	194,914,640.51
210101	Үндсэн цалин	84,918,800.00	84,386,352.87	137,550,500.00	109,853,360.78
210102	Нэмэгдэл	43,144,300.00	30,089,826.45	48,418,800.00	67,808,801.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,709,000.00	6,104,000.00	9,504,000.00	7,972,000.00
210104	Урамшуулал	00.00	4,749,854.90	00.00	9,280,478.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,029,100.00	15,666,254.35	24,434,100.00	24,321,532.56
210201	Тэтгэврийн даатгал	12,798,300.00	10,653,052.85	16,615,200.00	17,991,317.09
210202	Тэтгэмжийн даатгал	1,307,700.00	1,253,300.29	1,954,700.00	1,583,867.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,046,200.00	1,002,640.30	1,563,800.00	1,267,093.55
210204	Ажилгүйдлийн даатгал	261,500.00	250,660.09	390,900.00	311,520.82
210205	Эрүүл мэндийн даатгал	2,615,400.00	2,506,600.82	3,909,500.00	3,167,734.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,327,800.00	5,550,278.76	00.00	00.00
210301	Гэрэл, цахилгаан	300,000.00	00.00	00.00	00.00
210302	Түлш, халаалт	6,027,800.00	5,550,278.76	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,986,500.00	7,735,720.00	7,884,300.00	6,802,869.05
210401	Бичиг хэргэ	1,532,900.00	1,520,530.00	1,300,000.00	1,048,700.00
210402	Тээвэр, шатахуун	4,184,000.00	4,165,000.00	3,960,000.00	3,389,200.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр	1,177,700.00	945,670.00	1,674,300.00	1,577,619.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,091,900.00	1,104,520.00	950,000.00	787,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,729,300.00	1,673,180.00	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,729,300.00	1,673,180.00	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,007,300.00	12,641,500.00	18,882,000.00	18,000,000.00
210702	Дотоод албан томилолт	13,007,300.00	12,641,500.00	18,882,000.00	18,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	508,300.00	492,750.00	4,100,000.00	4,024,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	3,500,000.00	3,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	283,300.00	283,300.00	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	108,300.00	140,000.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,700.00	76,150.00	110,000.00	55,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00	30,000.00	30,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,345,700.00	2,890,000.00	20,217,000.00	17,932,370.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	18,535,900.00	16,251,270.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,345,700.00	2,890,000.00	1,681,100.00	1,681,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,866,700.00	2,813,100.00	4,650,000.00	3,908,885.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,866,700.00	2,813,100.00	4,650,000.00	3,908,885.28
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,866,700.00	2,813,100.00	4,650,000.00	3,908,885.28
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00	00.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	187,572,800.00	174,792,817.33	276,640,700.00	270,905,047.40
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	187,572,800.00	174,792,817.33	276,640,700.00	270,905,047.40
132001	Орон нутгийн төсвөөс	187,572,800.00	174,792,817.33	276,640,700.00	270,905,047.40
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	07	07	07	07
620001	Удирдах ажилтан	01	01	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	06	06	06	06

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн...” үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан Дотоод аудитын хороог 2 удаа хуралдуулж, 2022 оны үйл ажиллагааны тайлан, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын ажлын төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнан ажилласан байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 79 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас хэрэгжилт 94,82 %-тай “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023 онд байгууллагын дарга бөгөөд санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч 4, аудитор 1 гэсэн 7 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын алба нь 2023 оны санхүүгийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу Төв аймгийн Шуудан үйлчилгээний газар, Монголын цахилгаан холбоо ХК, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Статистикийн хэлтэс, Зуунмодны политехник коллеж, Мал эмнэлэгийн газар, Ойн ангиуд, Улсын бүртгэлийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, 14 сумдын төсөвт 90 байгууллагуудад, аймгийн нэгдсэн эмнэлэг, БЗОСК, ОНӨГ, Авто тээврийн төв, Татварын хэлтэс, аймгийн ЗДТГ-ын 2022 он, аймгийн төрийн сан, Төв чандмань ДЭХГ, Баянчандмань суман дахь Политехник коллеж, Аймгийн Засаг даргын тусгай сан, Төв эрдэнэс ОНӨҮГ, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021, 2022 оны үйл ажиллагаа, Сангийн Яамны нэгдсэн удирдамжийн дагуу Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт, өргөдлөөр Цээл сумын ЗДТГ, Сүмбэр сумын ЗДТГ, Баянжаргалан сумын соёлын төв, Төв чандмань ДЭХГ-ын ТУЗ-ын хүсэлтээр 2023 оны өглөг, авлагын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж 5,947,485.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 255,516.5 мянган төгрөгийн зөрчилд санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн акт тогтоож, 5,691,968.8 мянган төгрөгийн зөрчилд Улсын байцаагчийн албан шаардлага өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиглэлээр сумдын Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Баянцагаан сумын ЭМТ, Эрдэнэсант “А33А” ТӨХК, Сүмбэр сумын ЭМТ, Аргалант сумын ЭМТ, Архуст сумын ЭМТ, Баянжаргалан сумын ЗДТГ-ын 2022 оны үйл ажиллагаанд дотоод аудит, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, түүний зарцуулалтад хяналт тавьж 31,893.8 мянган төгрөгийн зөрчилд Улсын ахлах байцаагчийн акт, 628,809.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, нийт 660,703.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж ажилласан байна.

Тус алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 онд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж шалгагдсан тухайн

байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилгоо биелүүлэн ажилласан байна.

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитад хамрагдсан байгууллагуудын дүнгээр 6,608,188.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 6,320,778.3 мянган төгрөгийн 47 албан шаардлага хүргүүлж, 287,410.3 мянган төгрөгийн 180 төлбөрийн акт тогтоож 207,653.3 мянган төгрөгийг нь барагдуулсан байна. Өмнөх оны актын барагдаагүй үлдэгдэл 190,473.5 мянган төгрөгөөс 63,577.7 мянган төгрөгийн актыг барагдуулж, актын барагдуулалт 56,8 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтийг нэмж тусган мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус алба нь байгууллагын даргын 2015 оны 12 дугаар сарын 03-ны А/06 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэж, 2024 оны 1 дүгээр сарын 24-ний 33/03 албан тоотоор Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,903.6 мянган төгрөгөөр буюу 57,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Авлага	0.0	94.0	94.0
Бараа материал	2,979.0	5,249.4	2,270.4
Үндсэн хөрөнгө	17,902.5	27,441.7	9,539.2
Нийт хөрөнгө	20,881.5	32,785.1	11,903.6
Өр төлбөр	0.0	94.0	94.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	20,881.5	32,691.1	11,809.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	20,881.5	32,785.1	11,903.6

Дээрх хүснэгтээс харахад, бараа материалын үлдэгдэл 2,270.4 мянган төгрөгөөр өссөн нь тамга, тэмдэг дардас шинэчлүүлсэн болон вакум хаалт, баримт үдэгч, интернэт төхөөрөмж, тосон халаагч зэрэг аж ахуйн материалууд авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 9,539.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 4,113.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 9,132.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсан боловч 18,671.2 мянган төгрөгийн зөөврийн компьютер, принтер зэрэг тоног төхөөрөмжүүд худалдан авсан нь нөлөөлсөн байна.

Тайлант онд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлттэй холбоотой 94.0 мянган төгрөгийн ажиллагчидтай холбогдсон авлага үүсгэж, Татварын байгууллагад 94.0 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 32,691.1 мянган төгрөг болж 11,903.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 237,919.5 мянган төгрөг, нийт зарлагыг 237,919.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 25,577.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2023 оны урсгал зардлын төсвийг 263,497.4 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 02 дугаар тогтоолоор тайлант оны батлагдсан төсөв 263,497.4 мянган төгрөгийг 13,143.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,

276,640.8 мянган төгрөгөөр тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлага хөтөлбөрийн 2 арга хэмжээг 276,640.8 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 5,735.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 270,905.0 мянган төгрөг буюу 97,9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлаас 4,994.5 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлаас 741.1 мянган төгрөг, нийт 5,735.7 мянган төгрөгийг дутуу зарцуулж, орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70429- Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлага 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	271,990.7	266,993.2	4,994.5	98.2
2	70429- Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлага 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	4,650.0	3,908.9	741.1	84.1
	Дүн	276,640.7	270,905.1	5,735.6	97.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 42,665.2 мянган төгрөгийн орлого орж, байгууллагын даргын 2023 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн Б/19 тушаалаар тус албаны төрийн захиргааны албан хаагчдын орон нутагт ажилласны 70 хувиар тооцсон нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын зардалд 38,762.3 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 3,902.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт нэг хөтөлбөрийн хоёр арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт / мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70429- Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	2023.01.01-2023.12.31	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлага хөтөлбөр 97.9 %	276,640.7	270,905.1

Төв аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага /70429/ хөтөлбөр 97,9 % буюу 2,1 %-иар дутуу хэрэгжсэн нь 2023

оны төсвийн жилд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор хэмнэгдсэн 3,902.9 мянган төгрөгийн зардлыг татан төвлөрүүлсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу албан хаагчдын тавилга, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд 18,000.0 мянган төгрөгөөр 6 ширхэг зөөврийн компьютер, 2 ширхэг ширээг шууд худалдан авах журмын дагуу худалдан авч ажилласан байна.

Ерөнхий гэрээгээр худалдан авалт хийгдээгүй байна. Энэ нь цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, ажил үйлчилгээний сонголт бага, тоног төхөөрөмжийн өртөг зардал өндөр байгаа тул өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 33/03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны төсвийн төлөвлөгөөний нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлага 263,497.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,952.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,964.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор хэмнэгдсэн 3,902.9 мянган төгрөгийн зардлыг татан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 17, зарлагын 2 мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 16 шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн 2 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 33/24 тоотой ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	764.0	1	764.0	100
Албан шаардлага	0	0.0	0	0.0	0
Зөвлөмж	1	2,470.0	1	2,470.0	100
Нийт дүн	2	3,234.0	2	3,234.0	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй бөгөөд нийт 1,652.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсний 952.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 700.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан 7 ажилтанд 952.0 мянган төгрөгийн албан томилолтыг хичээл үйлдвэрлэлийн зардлаас гүйлгэн зарцуулж олгосон зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтооно гэж заасны дагуу шийдвэрлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Үр нөлөөтэй холбоотой асуудал***

1.1. Илрүүлэлт:

Гадаад албан томилолтын зардал батлагдаагүй байхад Аймгийн Засаг даргын 2023.10.13-ны А/701 захирамжаар гадаад томилолтын зардалд 700.0 мянган төгрөг дотоод албан томилолтын зардлаас зарцуулж, тайлагнасан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5.-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

